

ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР
ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА “ДОНШЕН ГАЗРЫН ТОС
(МОНГОЛ)” ХХК-ИЙН “БХГ-97” ТАЛБАЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨХ
ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН
ТООЦОО, ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ АУДИТ

Аудитын төлөвлөгөө

2018 он

АГУУЛГА

Аудитын нэр.....	1
Аудитын код.....	1
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	1
Аудитын зорилт	1
Аудитын хамрах хүрээ.....	1
Эрсдэлийн үнэлгээ	2
Аудитын арга зүй	2
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд.....	2
Үндсэн мэдээлэл.....	2-3
Аудит хийх багийн бүрэлдэхүүн.....	3-4
Аудит хийх хугацаа.....	4
Аудитын хөтөлбөр.....	4
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам.....	4
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц.....	4
Аудитын эрсдэлийн үнэлгээ /Хавсралт №1/	6-7
Асуудлын шинжилгээ /Хавсралт №2/	
Аудитын арга зүй /Хавсралт №3/	
Аудитын хөтөлбөр /Хавсралт №4/	
Аудитын үр өгөөж /Хавсралт №5/	
Материаллаг байдал /Хавсралт №6/	

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн “БХГ-97” талбайн хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит

2. Аудитын код

ҮАГ-НАГ-/2018/03-НА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.21-д тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн хийнэ.


4. Аудитын зорилт

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн “БХГ-97” талбайн 2014 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнасныг шалган баталгаажуулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн “БХГ-97” талбайд үйл ажиллагаа явуулж тайлагнасан 2014 оны өртөг нөхөх зардал нь хууль, тогтоомж болон БХГ-ний холбогдох заалтуудын дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнасан эсэх;
- “Доншен газрын тос (Монгол)” ХХК нь “БХГ-97” талбайд 2014 онд үйл ажиллагаа явуулахдаа газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг хууль, тогтоомж болон БХГ-ний холбогдох заалтын дагуу хийж үнэн зөв бүртгэж, тайлагнасан эсэх.

5. Аудитын хамрах хүрээ



Аудитаар бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт, экспортын үйл ажиллагаа явуулж буй “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн “БХГ 97” талбайд 2014 онд оруулсан хөрөнгө оруулалт, хийж гүйцэтгэсэн ажил, өртөг нөхөгдөх зардал, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт, батлагдсан төсөв, төлөвлөгөө, холбогдох тайлан, мэдээ, судалгааг авч үзнэ.

6. Эрсдэлийн үнэлгээ

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн аудитын эрсдэлийг “Дунд” гэж үзлээ. /Дэлгэрэнгүйг хавсралт №1-т үзүүлэв/

7. Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 805, АДБОУС 1805, АДБОУС 4000, Төрийн хяналт шалгалтын стандарт, МУЕА-ын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журам, 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/139 дүгээр тушаалаар батлагдсан “Газрын тосны өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах аудитын заавар”-ыг баримтлан “БХГ-97” талбайн 2014 оны өртөг нөхөх зардлын тайлан болон газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг ажил гүйлгээ тус бүрээр нь Газрын тосны газар /хуучин нэрээр/-аар батлуулсан тухайн жилийн ажлын хөтөлбөр, төсөв, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн ерөнхий журнал, ерөнхий дэвтэр болон анхан шатны баримттай нь тулган баталгаажуулах, холбогдох мэргэжилтнүүдээс шаардлагатай баримт, материал, лавлагаа тайлбар авах зэрэг аудитын горимуудыг гүйцэтгэн нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулна. /Дэлгэрэнгүйг хавсралт №2, №3-т үзүүлэв/

8. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Газрын тосны тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Бүтээгдэхүүн хуваах гэрээ, гэрээлэгчтэй байгуулсан нэмэлт протоколууд;
- Холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар.

9. Үндсэн мэдээлэл

Газрын тосны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг УИХ-аас 1991 онд баталсан Газрын тосны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор баталсан “БНМАУ-ын Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-аар зохицуулж ирсэн бөгөөд 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр УИХ-аас тус хуулийн шинэчилсэн найруулгыг батлан мөрдөж эхэлсэн байна.

Өнөөгийн байдлаар газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын 32 талбай ялгаснаас 25 талбайд 21 гэрээлэгч Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан, Монгол Улсын Засгийн газраар батлуулан үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын хэмжээнд 1996-2016 оны хооронд нийт 43.8 сая баррель (5.9 сая тонн) газрын тос олборлож, 41.6 сая баррель (5.6 сая тонн) газрын тосыг БНХАУ-д экспортолж, газрын тосны орлогоос нийт 1.1 их наяд төгрөгийг Монгол Улсын төсөвт төвлөрүүлжээ.

БНХАУ-ын “Доншен Жингүн Петролеум Девелопмент Групп Сток” компани нь Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 47 дугаар тогтоолоор батлагдсан “БХГ-97” талбайн эрх, үүргийг 2003 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Австралийн “Рок Ойл (Говь)” ХХК-аас бүрэн шилжүүлэн авч, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийг байгуулан тус талбайд үйл ажиллагаа явуулж байна.

АМГТГ-аас ирүүлсэн мэдээллээр “БХГ-97” талбайд 2014 онд нийт 22,013,093.0 ам.долларын ажил хийхээр хөтөлбөр, төсвөө батлуулснаас гүйцэтгэлээр 14,354,095.3 ам.долларын зардлыг өртөг нөхөхөөр тайлагнасан байна. Хүснэгтээр харуулбал:

/ам.доллар/

Он	Төлөвлөгөө, төсөв	Хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардал
2014	22,013,093.0	14,354,095.3

Эх сурвалж: АМГТГ-ын 2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 9/2798, 06 дугаар сарын 11-ний өдрийн 9/4203 дугаар албан бичиг

Мөн тус талбайгаас 2014 онд нийт 442,212.79 баррель тос олборлож, 44,319,154.92 ам.долларын борлуулалт хийснээс МУЗГ-т 2,980,449.62 ам.долларын нөөц ашигласны төлбөр, 8,307,008.74 ам.долларын ашигт газрын тос ногдсон байна. Хүснэгтээр харуулбал:

/ам.доллар/

Он	Борлуулсан газрын тос /Баррель/	Нийт борлуулалтын орлого	Бүтээгдэхүүн хуваалт			
			Роялти /7.5%/	Өртөгт тос /40%/	Гэрээлэгчид ногдох	МУЗГ-т ногдох
2014	442,212.79	44,319,154.92	2,980,449.62	15,673,188.98	12,778,676.04	8,307,008.74

Эх сурвалж: АМГТГ-ын 2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 9/2798, 06 дугаар сарын 11-ний өдрийн 9/4203 дугаар албан бичиг

10. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Энхбаатар хянан удирдаж, аудитын менежер Х.Болдбаатар аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, ахлах аудитор Б.Алтансүх, аудитор Л.Нямтөмөр, Б.Чимэдлхам болон гэрээт хуулийн этгээд, мэргэжлийн зөвлөх нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.

11. Аудит хийх хугацаа

Аудитыг 2018 оны 10 дугаар сарын 29-нд эхэлж, 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн дотор тайлангийн төслийг бэлтгэн Аудитын зөвлөлийн хурлаар

хэлэлцүүлж, 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн дотор Чанарын баталгаажуулалтын албаар хянуулан, МУЕА-ын тушаалаар баталгаажуулж, 2018 оны 12 дугаар сарын 28-ны дотор УИХ-д хүргүүлнэ.

12. Аудитын хөтөлбөр

Аудитын хөтөлбөрийг энэхүү төлөвлөгөөний хавсралт №4-т үзүүлэв.

13. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, товч тайлан гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг аудитын зорилт тус бүрээр гаргана.

Аудитын тайлангийн төсөл болон гэрээлэгчид олгох аудитын гэрчилгээг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн зөвшөөрлөөр холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан санал авч, Аудитын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

14. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц

а. Боловсон хүчин: УАГ - 34* 3 хүн - 102 хүн/өдөр

Гэрээт аудитын хуулийн этгээд - 30* 4 хүн - 120 хүн/өдөр
Зөвлөх шинжээч - 30* 3 хүн - 90 хүн/өдөр

б. Санхүүгийн нөөц:

УАГ-аас цалингийн зардал - 3.800,0 мянган төгрөг

Гэрээт хуулийн этгээдийн зардал - 8,000.0 мянган төгрөг

Томилолтын зардал - 7,412.0 мянган төгрөг

Зөвлөхийн зардал төлөвлөлтийн шатанд - 4,000.0 мянган төгрөг


Зөвлөхийн зардал гүйцэтгэлийн шатанд - 20,588.0 мянган төгрөг

в. Аудитын нийт зардал: 40,000.0 мянган төгрөг


г. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, дуу хураагуур, хувилагч, скайнер, фото аппарат болон бусад техник хэрэгсэл.

Аудитын төлөвлөгөөг

Танилцсан:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  С.ОЮУНБИЛЭГ

Хянасан:

НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  С.ЭНХБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Б.АЛТАНСҮХ
Л.НЯМТӨМӨР
Б.ЧИМЭДЛХАМ

Аудитын төлөвлөлтийн үе шатанд газрын тосны олборлолт, ашиглалттай холбоотой нарийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн зөвлөхийн баг:

ШУТИС-ИЙН ГАЗРЫН ТОСНЫ ЗӨВЛӨХ,
ПРОФЕССОР, ТЕХНИКИЙН УХААНЫ ДОКТОР

Ж.ЦЭВЭЭНЖАВ

ГАЗРЫН ТОСНЫ ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР

Д.ЦЭДЭНБАЛЖИР